



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Дугаар: 2012/3

Мөрдөх огноо: 2012 оны 3-р сарын 19

Эмбарго: 2012 оны 3-р сарын 16-ны Баасан гарагийн 11:00 цаг хүртэл

Монголбанкны Захирлуудын зөвлөлийн 2012 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хурлаас бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлэн 12.75 хувьд хүргэх шийдвэр гаргалаа.

ҮСХ-оос 2012 оны 2 дугаар сарын байдлаар хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ээр хэмжсэн инфляци улсын хэмжээнд жилийн 12.5 хувь, Улаанбаатар хотынх жилийн 13.3 хувьд тус тус хүрснийг мэдээлэв. Манай эдийн засаг 2012 онд үнийн өсөлтийг эрчимжүүлэх нийлүүлэлтийн сөрөг хүчин зүйлсийн нөлөөлөлд өртөж байна. Мах, махан бүтээгдэхүүний үнэ оны эхнээс 29.6 хувиар өсч Улаанбаатар хотын эхний 2 сарын инфляцийн 58 хувийг бүрдүүлэх боллоо. Шатахууны үнэ 15.6 хувиар өссөн байна. Хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ нийтдээ мөн хугацаанд 2.4 хувиар өсч нийт инфляцийн 31 хувийг бүрдүүлэв. Эрэлтийн хүчин зүйлээс хамаарах инфляци буурахгүй байгааг энэ үзүүлэлт харуулж байна.

2012 оны төсвийн тодотгол эдийн засаг дах илүүдэл эрэлтийг өсгөж, улмаар эрэлтийн төдийгүй нийлүүлэлтийн инфляцийг нэмэгдүүлж байна. Иймд Монголбанк инфляцийг хязгаарлах, гадаад валюттай харьцах төгрөгийн ханшинд ирэх дарамтыг бууруулах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалах зорилгоор төгрөгийн хүүний бодит өгөөжийг нэмэгдүүлэн мөнгөний бодлогыг чангаруулах арга хэмжээг авч байна. Монголбанк инфляцийг хязгаарлах арга хэмжээг шаардлагатай тохиолдол бүрд цаашид авч байх болно.

МОНГОЛБАНК